ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ М.ЖАВХЛАНТӨГСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 1 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 90% | 50% | **Биелэлт:**<br>Гаалийн байгууллагын 2024 оны жилийн эцсийн дараах эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг Сангийн яаманд болон АТГ-д тус тус хүргүүлсэн.Үүнд:<br>1.Сангийн яамны 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 03/1172 албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн тайлан. /2025.01.27-ны өдрийн 01/427 албан бичиг/,<br>2.ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн тайлан /2025.01.20-ны өдрийн 02/272 албан бичиг/,<br>3.Агентлагийн хүрээнд хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан /2025.01.10-ны өдрийн 01-1/133 албан бичиг/,<br>4.Гаалийн байгууллагын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах хүснэгт тайлан /2025.01.27-ны өдрийн 01/427 албан бичиг/,<br>5.Аудит, хяналт шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийн тайлан /2025.01.27-ны өдрийн 01/427 албан бичиг/,<br>6.Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээний тайлан /2025.01.27-ны өдрийн 01/427 албан бичиг/,<br>7.“Гаалийн байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний биелэлтийн тайлан /2025.01.03-ний өдрийн 01-1/16 албан бичиг/,<br>8.“Гаалийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний биелэлтийн тайлан /2025.01.03-ний өдрийн 01-1/16 албан бичиг/,<br>9.Улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтийн тайланг ХШҮДАГ-т хүргүүлсэн,<br>10.Агентлагийн бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тайланг ХШҮДАГ-т хүргүүлсэн,<br>11.“АТГ-аас ГЕГ-т ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийн тайлан. /2025.01.27-ны өдрийн 01/427 албан бичиг/,<br>12.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан. /2025.01.31-ний өдрийн 01/538 албан бичиг/,<br>Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үндэслэн “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гаалийн байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөө”-г Гаалийн ерөнхий газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Сангийн сайдын 2018 оны 143 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад заасны дагуу Гаалийн байгууллагын 2024 оны жилийн эцсийн эрх зүйн акт, бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны хэрэгжилтийн 12 тайланг нэгтгэн боловсруулж, СЯ-нд болон АТГ-т хугацаанд нь хүргүүлж, ажилласан. Хугацаа хоцроосон тайлан байхгүй болно. | | |
| 2 | Гаалийн байгууллагын стратеги төлөвлөгөө болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг тооцож тайлагнах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 60% | 50% | **Биелэлт:**<br>1.Гаалийн байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, Сангийн сайдаар батлуулж, www.gov.mn-д байршуулсан.<br>2.Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын дарга нарын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан аргачлал, загварын дагуу боловсруулах талаар зөвлөмж өгч, дэд дарга болон ГЕГ-ын 25 бүтцийн нэгж болон Харьяа гаалийн газар, хороодын дарга нарын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, архивын нэгж үүсгэн хүлээлгэн өгсөн. ГЕГ-ын ЗББНДБ-ын сарын, долоо хоногийн төлөвлөгөө, тайлангийн программын хөгжүүлэлтэд хяналт тавьж, ашиглалтад оруулсан.<br>3.Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын нийт 246 төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хүлээн авч, нэг хувийг 2025.03.27-ны өдөр Хүний нөөцийн хэлтэст хүлээлгэн өгсөн. 2 дахь хувийг мөн өдөр архивын нэгж үүсгэн архивын эрхлэгчид хүлээлгэн өгсөн. Харьяа гаалийн газар, хороодын төрийн жинхэнэ албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан аргачлал, загварын дагуу боловсруулж, нэгжийн даргаар батлуулах тухай зөвлөмжийг харьяа гаалийн газар, хороодод өгч ажилласан.<br>4. Гаалийн байгууллагын 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг ГЕГ-ын ЗББНДБ-аас хүлээн авах ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд тайланг Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.<br>5.Гаалийн ерөнхий газрын төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн тайланг, үнэлгээний хуудасны хамт хүлээн авах ажлыг Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга хэрэгжүүлэн ажиллаж байна. Захиргааны удирдлагын газрын гаалийн улсын байцаагч нар 2025 оны эхний хагас жилийн тайлан, үнэлгээний хуудасны хамт Үнэлгээний багт хүргүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Гаалийн байгууллагын стратеги төлөвлөгөө болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг тооцож тайлагнах ажлын хэрэгжилт бүрэн хангагдсан. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Хөдөлмөрийн дотоод журам, Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандартын хэрэгжилт, үр дүнг тооцож тайлагнах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 90% | 50% | **Биелэлт:**<br>1."Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг ГЕГ-ын ЗББНДБ болон ХГГХ-оос авч, ирүүлсэн саналыг төсөлд тусгасан ажилласан. ГЕГ-ын даргын 2025 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэгт Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын төслийг танилцуулж, гишүүдийн саналыг тусган эцэслэн боловсруулж, ажлын хэсгийн нарийн бичигт хүргүүлэн ажилласан.<br>2. ЗУГ-ын даргаар батлуулсан “Мэдээллийн цаг”-ийг төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд нийт 9 удаагийн мэдээлэл өгөх ажил зохион байгуулахаас 11 удаа зохион байгуулсан.<br>3. Тайлант хугацаанд энгийн 1216, чиптэй 232 ажлын үнэмлэхийг захиалж, албан хаагчдад олгосон. Төрийн ордонд нэвтрэх үнэмлэхийн мэдээллийг ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга Б.Солонгод ГЕГ-ын 2025.01.03-ны өдрийн 01-1/27 албан бичгээр, төрийн ордонд ажиллаж байгаа ажлын хэсгийн нэвтрэх үнэмлэхийн захиалгыг 02/1783 албан бичгээр хүргүүлж, үнэмлэхийг сунгуулан удирдлагуудад өгсөн.<br>4. ГЕГ-ын даргын 2025 оны А/137 тушаалаар "ГЕГ болон ХГГХ-ын албан хаагчдад үр дүнгийн шагнал, мөнгөн урамшууллын зардлыг хуваарилах тухай" 2,642,625,000 төгрөг, 2025 оны Б/199 тушаалаар "ХГГХ-ын дарга нарт улирлын ажлын үнэлгээг баталж, үр дүнгийн шагнал олгох тухай", 2025 оны Б/259 тушаалаар "ГЕГ-ын ЗББНДБ-ын албан хаагчдын 1 дүгээр улирлын ажлын үр дүнгээр олгох шагналд /урамшуулалд/ 372,819.188 сая төгрөгийг олгох ажлыг тус тус зохион байгуулсан.<br>5. Гаалийн байгууллагын албан хаагчдын хувийн болон энгэрийн тэмдгийг хадгалж байгаа бөгөөд тус хугацаанд шинээр хадгалуулсан 43 албан хаагч, хувийн олон энгэрийн тэмдгийг хүлээлгэн өгсөн 6, шинээр олгосон 80 албан хаагч байна.<br>6. Удирдах албан тушаалтны ажил хүлээлцэх акт үйлдсэн тохиолдолд бүртгэгдээгүй.<br>7. Нийт 80 гаалийн улсын байцаагчийн тангараг өргүүлэх ажил зохион байгуулсан.<br>8. Гаалийн удирдах төв байгууллагын дарга, удирдлагуудын иргэд, ААН-ийн төлөөллийг хүлээн авч, уулзах уулзалтын хуваарийг ажлын 5 өдрөөр гаргаж, мэдээллийн самбарт болон цахим хуудсанд байршуулсан.<br>9. ГЕГ-ын даргын 2016 оны А/69 тушаалаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт”, 2021 оны А/251 тушаалаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар ХГГХ-д 2025.01.13-ны өдрийн 01-1/157 албан бичгээр, ЗББНДБ-д 2025.01.13-ны өдрийн 01100/1 дотоод зурвасаар чиглэл хүргүүлсэн.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Хөдөлмөрийн дотоод журам, Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандартын хэрэгжилт хангагдсан. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Албан хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, албан хаагчийн хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 90% | 50% | **Биелэлт:**<br>Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын төсөлд холбогдох заалтыг тусгуулж ажилласан.<br>Албан хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, албан хаагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд:<br>1.ГЕГ-ын даргын 26 удирдамжийн дагуу албан томилолтоор ажиллах болсон албан хаагчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулж, гарын үсэг зуруулан ажилласан.<br>2.ГЕГ болон харьяа гаалийн газар, хороодын нийт 21 албан хаагчийг “Эрхэс сувд” ХХК-ийн 124 цагийн “ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалт”-д цахимаар хамруулах ажлыг зохион байгуулсан.<br>3.“Хамгийн чухал нь эрүүл мэнд" зорилтот хөтөлбөрийн хүрээнд хөдөө, орон нутагт ажиллаж, амьдардаг төрийн тусгай албан хаагчид болон тэдний гэр бүлийнхэнд хиймэл оюун ухаанд суурилсан хэт авианы болон биеийн найрлага тодорхойлох оношилгоо, лабораторийн шинжилгээ, зүрхний цахилгаан бичлэг, эрсдэлийн үнэлгээ хийх зэрэг үзлэг, шинжилгээнүүдийг хийж, эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлж байгаа дээрх арга хэмжээнд гаалийн байгууллагын хөдөө, орон нутагт ажиллаж, амьдарч байгаа албан хаагчдыг хамруулж өгөхийг хүссэн хүсэлтийг ТТАХНЭ-т 2025.05.01-ний өдрийн 01-1/1805 албан бичгээр хүргүүлсэн.<br>4.Албан үүргээ гүйцэтгэх явцад зам тээврийн осолд өртсөний улмаас нарийн мэргэжлийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээнд зарцуулсан зардлаа буцаан авах хүсэлт гаргасан Гаалийн ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч Ж.Батцэнгэлд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т заасны дагуу 633000 /Зургаан зуун гучин гурван мянга/ төгрөгийн зардлыг олгох асуудлыг 2025.04.02-ны өдрийн Захиргааны зөвлөлийн 3 дугаар хуралдаанд танилцуулж, дэмжигдсэн тул тус хуралдааны 03/01 дугаар шийдвэрийг СХОГ-т хүргүүлэв.<br>5. УОК-ын 2025 оны 02 дугаар албан даалгаврын дагуу харьяа гаалийн газар, хороодоос хэрэгжүүлсэн ажлын тайланг хүлээн авч, нэгтгэн боловсруулж, нийт 4 удаа /2025.04.15-ны өдрийн 01-1/1522, 2025.04.30-ны өдрийн 01-1/1779, 2025.05.15-ны өдрийн 02/2023, 2025.05.30-ны өдрийн 01-1/2300 албан бичгүүдээр/ тайланг тус тус хүргүүлсэн.<br>2024 онд хийлгэсэн судалгааны дагуу Үндэсний итгэмжлэлийн төвөөс ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийхээр итгэмжлэгдсэн техникийн хяналтын7 байгууллагатай холбогдож, зарим ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх үнийн саналыг авсан байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Албан хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, албан хаагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр төлөвлөсөн ажлын хэрэгжилт хангагдсан. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Мэргэжлийн зөвлөл, Захиргааны зөвлөлийн хуралдаан болон цахим, шуурхай хурлын шийдвэрийн хэрэгжилт, үр дүнг тооцож тайлагнах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 82% | 50% | **Биелэлт:**<br>1.ГЕГ-ын 2025 оны Захиргааны зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөг ЗББНДБ-аас санал авч нэгтгэн боловсруулж, батлуулсан. Захиргааны зөвлөлийн ээлжит болон ээлжит бус нийт 4 хуралдааныг дэгийн дагуу зохион байгуулсан. Хуралдаанаар нийт 12 асуудлыг хэлэлцүүлэн 13 шийдвэр гарсан. Хуралдаанаас гарсан шийдвэрийг хэвлэмэл хуудсаар болон ЗДАС программаар ЗУГ-1, ХШҮДАГ--5, СХОГ -3, ХХ -1, БАҮХ -1, ДХАБХ -1, СТ -1, СЭГГ -1 тус тус хүргүүлж, сан үүсгэн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. ЗЗХ-ны тэмдэглэлийг тухай бүр хөтөлж, архивын нэгж үүсгэж ажилласан.<br>2. Тайлант хугацаанд Мэргэжлийн зөвлөлийн хуралдааныг 6 удаа зохион байгуулж, нийт 28 асуудлыг хэлэлцүүлснээс 30 асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна. ГЕГ-ын “Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан”-аас гарсан 30 шийдвэрийг хэвлэмэл хуудсаар болон ЗДАС программаар ХБГ -24, БДШГ -1, ХШҮДАГ -2, ХХ -2, БАҮХ -1, МТГ -1 тус тус хүргүүлж ажилласан. Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг тухай бүр хөтөлж, архивын нэгж үүсгэсэн.<br>3. Гаалийн байгууллагын “Онлайн хуралдаан” нийт 18 удаа болж хуралдаанаас өгөгдсөн цар хүрээ өндөртэй 2 үүрэг даалгаврыг тухай бүр ЗДАС программын “Үүрэг даалгавар” цэсэд оруулж, биелэлтэд хяналт тавин ажилласан. Хуралдааны бэлтгэл ажлыг Мэдээллийн технологийн төвтэй хамтран ханган ажилласан. Цахим хуралдаанд ГЕГ-ын дэд дарга 1, ТОГ-ын даргын 1 үүрэг даалгаврыг бүртгэж оруулсан.<br>4. Тайлант хугацаанд нийт 19 удаа Шуурхай хуралдаан зохион байгуулсан. Хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврыг газрын дарга биечлэн танилцуулах чиглэлийг өгсөн тул ЗДАС программын “Үүрэг даалгавар” цэсэд оруулаагүй болно. ГЕГ-ын даргын 2022 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан гаалийн байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2.12-д заасны дагуу “Шуурхай хуралдаан”-ыг долоо хоног бүрийн Даваа гарагт зохион байгуулан ажилласан.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Мэргэжлийн зөвлөлийн 6, Захиргааны зөвлөлийн 4, цахим 18 хуралдааны бэлтгэл ажлыг ханган, шуурхай зохион байгуулан ажилласан байна. Захиргааны зөвлөлийн хурал болон мэргэжлийн зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг тухай бүр хөтөлж, архивын нэгж үүсгэн ажилласан. | 01.01-06.10 | 100 |
| 6 | Архив, албан хэрэг хөтлөлтийн дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 88% | 50% | **Биелэлт:**<br>1. Гаалийн байгууллагын 2025 оны архивын үйл ажиллагааны төлөвлөгөөг ГЕГ-н даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>2. Архив, албан хэрэг хөтлөлтийн дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг бүрэн хангуулан ажилласан.<br>3. ЗББНДБ-д 01100/23 тоот дотоод зурвасаар 2025 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлуулан ирүүлсний дагуу хийж, 2025.03.17-ны “Баримт нягтлан шалгах комисс”-ын 01 дүгээр хурлаар хэлэлцүүлж, байгууллагын ХХНЖ-ыг 2025.03.27-ны өдөр батлуулан хэрэгжүүлж байна.<br>4. ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу албан бичгийн EDOC программд хөгжүүлэлт хийлгэх талаар 2025-02-26-нд 01100/33 тоот дотоод зурвасаар МТГ- | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | т хүргүүлсний дагуу Нью Соник ХХК-д саналаа хүргүүлж, нэмэлт хөгжүүлэлтийг 40 хувьтай хийж байна.<br>5. Албан бичгийг кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор албан хэрэг хөтлөлтийн хос хэлний программыг https://edoc.ecustoms.mn/ программд суулгуулах талаар саналаа солилцоод МТГ-тай хамтран ажиллаж байна. Тухайн программд "Нью соник" ХХК-аар хөгжүүлэлт хийлгүүлж байна.<br>6. Хэвлэмэл хуудасны зарцуулалт ГЕГ-ийн хэмжээнд өнгөрсөн онд 6382 байсан бол энэ онд 5944 хэвлэмэл хуудасны зарцуулалттай буюу 3.5 хувиар хэмнэгдсэн байна.<br>7. Баримт бичгийн стандарт MNS5140:2021" болон "Албан хэрэг хөтлөлтийн журам"-ын талаар ГЕГ-аас зохион байгуулсан гаалийн албаны анхан шатны мэдлэг олгох гаалийн чиглүүлэх курсийн 40 суралцагчдад 1.30 цагийн хичээл орсон.<br>8. Хэвлэмэл хуудасны зарцуулалт ГЕГ-ийн хэмжээнд өнгөрсөн онд 7072 байсан бол энэ онд 6382 хэвлэмэл хуудасны зарцуулалттай буюу 9.8 хувиар хэмнэгдсэн байна.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах ажлын хэрэгжилт бүрэн хангагдсан. | | |
| 7 | Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, удирдамж чиглэлээр хангаж ажилласан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 76% | 50% | **Биелэлт:**<br>1. ЗУГ-ын даргын баталсан төлөвлөгөөний дагуу өөрийн нэгжид харьяалагдах 3 хэлтэс /ХНХ, ХХ, ГХАХ/, 3 дэргэдэх байгууллага /СТ, ОНХА, ААУХ/-ыг ЗУГ-ын албан хаагч тус бүрт хариуцуулан нэгж хоорондын уялдаа холбоо, удирдлага арга зүйгээр ханган ажиллах зорилгоор хариуцуулан ажиллаж байна.<br>2. Гаалийн ерөнхий газрын 25 зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон 19 харьяа гаалийн газар, хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тэдгээрийн дарга нарын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж, батлуулах ажлыг зохион байгуулсан.<br>3. Долоо хоног бүрийн Даваа гарагт шуурхай хуралдааныг ЗУГ-ын дарга Б.Хосбаяр даргалан Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага хоорондын уялдаа холбоог удирдлага арга зүйгээр ханган ажиллаж шуурхай хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаварт тус нэгж бүрэн хяналт тавин ажиллаж байна.<br>4. Долоо хоног бүрийн Даваа гарагт харьяа гаалийн газар, хороодтой цахим хуралдааныг ЗУГ-ын дарга Б.Хосбаяр даргалан харьяа гаалийн газар, хороодын уялдаа холбоог удирдлага арга зүйгээр ханган ажиллаж цахим хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаварт тус нэгж бүрэн хяналт тавин ажиллаж байна.<br>5. "Гаалийн байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний дагуу харьяа гаалийн газар, хороодын төлөвлөгөөг ЗУГ-ын албан хаагчид хариуцаж, хариуцсан газар, хороодын төлөвлөгөөг ЗДАС-т оруулахад хяналт тавьж тухай | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүр утас болон вайбер, дотоод сүлжээгээр удирдлага арга зүйгээр хангаж ажилласан.<br>6. "ГУБ-ийн үйлчилгээний стандарт", "ГУБ-ийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам"-ыг албан хаагчдаа танилцуулах ажлыг зохион байгуулж, гарын үсгээр баталгаажуулан ирүүлэх, журмын хэрэгжилтийг ханган ажиллах талаар 2025.01.13-ний өдрийн 01-1/157 албан бичгийг ХГГХ-дод, 2025.01.13-ний өдрийн 01100/1-р дотоод зурвасыг ГЕГ-ын ЗББНДБ-д хүргүүлсэн.<br>7.Тус нэгжийн ГУАБ, ГУБ нар хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагад тухай бүр нь чиглэл, зөвлөмж өгч ажилласан.<br>Нийт 50 дотоод зурвасыг хүргүүлсэн байна. Үүнд:<br>- Хүний нөөцийн хэлтэст 8,<br>- Хуулийн хэлтэст 18,<br>- Гадаад хамтын ажиллагааны хэлтэст 4,<br>- Аж ахуй, үйлчилгээний албанд 7,<br>- Олон нийттэй харилцах албанд 8,<br>- Сургалтын төвд 5.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааг захиргааны удирдлагаар хангах ажлын хүрээнд Захиргааны удирдлагын газрын дарга Б.Хосбаяр долоо хоног бүрийн даваа гаригт цахим, шуурхай хуралдаанаар ГЕГ-ын ЗББНДБ-ууд болон харьяа гаалийн газар, хороодын дарга нарт үүрэг, чиглэл өгөн уялдаа холбоог ханган ажилласан. Хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаварт тус нэгж бүрэн хяналт тавин ажиллаж байна. Захиргааны удирдлагын газарт харьяалагдах нэгжүүдийн уялдаа холбоог хангах чиглэлээр тус нэгжээс нийт 50 дотоод зурвасыг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Цаг үеийн шижтэй мэдээллийг ЗББНДБ-уудын гаалийн улсын ахлах байцаагч нарын дундын VIBER группэд мэдээллийг тухай бүр мэдээлэн ажилласан. | | |
| 8 | Авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан ажил | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, үнэлгээгээр | 95% | 50% | **Биелэлт:**<br>1."Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгагдсан Гаалийн байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны тайланг 2025.01.31 өдрийн 01/538 албан бичгээр АТГ-ын АТҮХ-ийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар М.Даваатогтоход, 2025.01.31 өдрийн 01/539 албан бичгээр ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга, Б.Солонгод тус тус хүргүүлсэн. Мөн АТГ-ын khutulbur.iaac.mn программд биелэлтийг хугацаанд нь оруулсан.<br>2."Гаалийн байгууллагын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулан, АТГ-т хянуулахаар хүргүүлж, ГЕГ-ын даргаар батлуулан, ГЕГ-ын ЗББНДБ, ХГГХ-д хүргүүлсэн.<br>3."Гаалийн байгууллагын Шударга байдлын үнэлгээг 2025 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө"-г 2025.03.13-ны өдөр ГЕГ-ын даргаар батлуулж, 01100/38 дугаар ДЗ-аар ГЕГ-ын ЗББНДБ-д, 01-1/1015 албан бичгээр ХГГХ-д хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах чиглэлийг өгсөн. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4. 2025.03.26-ны өдөр ГЕГ-ын ЗББНДБ-ын ГУАБ нарт “Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” болон “Гаалийн байгууллагын Шударга байдлын үнэлгээг 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө”-ний биелэлтийг танилцуулж, “Гаалийн байгууллагын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу хийх ажлын чиглэл, зөвлөмжийг өгсөн.<br>5.“Гаалийн байгууллагын Шударга байдлын үнэлгээг 2025 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө”-ний дагуу “Баталгааны маягт”-ын загвар гаргаж, төрийн тусгай албан хаагч нараар баталгаа гаргуулан 2025.04.20-ны өдрийн дотор ирүүлж ажиллах чиглэлийг ЗУГ-ын 2025.04.08-ны өдрийн 01-100/49-р ДЗ-аар ГЕГ-ын ЗББНДБ-д хүргүүлсэн. Баталгааны маягтыг ГЕГ-ын 25 ЗББНДБ, 19 ХГГХ-оос авч нэгтгэсэн. Гаалийн байгууллагын хэмжээнд баталгаа гаргавал зохих нийт 1566 албан хаагчаас 1446 албан хаагч байна. Энэ нь нийт албан хаагчдын 92.3%-ийг эзэлж байна.<br>6.“Гаалийн байгууллагын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах ажлыг хийсэн. Үүнд:<br>6.1.Иргэд, олон нийтэд гаалийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааг сурталчлах, авлигын хор хөнөөлийг ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулах, түүнд уриалсан мэдээлэл түгээх зорилгоор ИААН-ийн төлөөлөлд тараах материалын эх загварыг гаргаж, 2025.04.30-ны өдрийн дотор ирүүлэх талаар ЗУГ-ын 2025.04.08-ны өдрийн 01100/47-р ДЗ-ыг ГЕГ-ын ЗББНДБ-д хүргүүлсэн.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>1. ”Гаалийн байгууллагын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулан, АТГ-т хянуулж, ГЕГ-ын даргаар батлуулан, ГЕГ-ын ЗББНДБ-уудад дотоод зурвас ХГГХ-д албан бичгээр тус тус хүргүүлэн ажилласан. Эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг ЗББНДБ-ууд болон харьяа гаалийн газар, хороодоос авч нэгтгэн АТГ-т хугацаанд нь хүргүүлэхээр ажиллаж байна. Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний хагас жилийн үнэлгээ АТГ-аас 100 хувиар үнэлэгдсэн.<br>2. “Гаалийн байгууллагын Шударга байдлын үнэлгээг 2025 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө”-ний төслийг боловсруулан, ГЕГ-ын даргаар батлуулан, ГЕГ-ын ЗББНДБ-уудад дотоод зурвас ХГГХ-д албан бичгээр тус тус хүргүүлэн ажилласан. Эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг ЗББНДБ-ууд болон харьяа гаалийн газар, хороодоос авч нэгтгэн АТГ-т хүргүүлэхээр ажиллаж байна. Гаалийн байгууллагын Шударга байдлын үнэлгээг 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний эхний хагас жилийн үнэлгээг АТГ-аас ирүүлээгүй.<br>3. Тайлант хугацаанд АТГ-аас ирүүлсэн нийт 3 зөвлөмжийн биелэлтийг эхний хагас жилийн байдлаар холбогдох ЗББНДБ-уудаас авч, нэгтгэн 2025 оны 06 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэхээр ажиллаж байна. /ЗУГ-2 зөвлөмж, ХХ-1 зөвлөмж/ | | |
| 9 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 88% | 50% | **Биелэлт:**<br>Захиргааны удирдлагын газрын чиг үүрэгт хамааралтай дараах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнасан. Үүнд:<br>1.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан Гаалийн байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны тайланг 2025.01.31-ний өдрийн 01/538 албан бичгээр АТГ-ын АТҮХ-ийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар М.Даваатогтоход, 2025.01.31-ний өдрийн 01/539 албан бичгээр ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга, Б.Солонгод тус тус хүргүүлсэн. Мөн АТГ-ын khutulbur.iaac.mn программд биелэлтийг хугацаанд нь оруулсан. АТГ-ын АТҮХ-ийн хэрэгжилтийн үнэлгээгээр ГЕГ нь ЗГ-ын 34 агентлагаас 3-р байрт орсон байна.<br>2. “Гаалийн байгууллагын авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-г ГЕГ-ын даргаар батлуулж, холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн. Эхний хагас жилийн явцын тайланг 2025.06.02-ны өдөрт багтаан khutulbur.iaac,mn программд оруулсан.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Захиргааны удирдлагын газрын чиг үүрэгт хамааралтай “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан Гаалийн байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны тайланг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Мөн “Гаалийн байгууллагын авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн биелэлтийг хугацаанд нь khutulbur.iaac,mn программд оруулсан. | 01.01-06.10 | 100 |
| 10 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилтийг хугацаанд тайлагнах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 50% | **Биелэлт:**<br>1. Захиргааны удирдлагын газрын чиг үүрэгт хамаарах тогтоол, шийдвэрийн 1-р улирлын биелэлтийг Хуулийн хэлтэст хүргүүлсэн.<br>2. ГЕГ-ын даргын 2025 оны Ажлын хэсэг байгуулах тухай А/173 дугаар тушаалаар батлагдсан ажлын хүрээнд ГЕГ-ын бүтцийн тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэгт дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлсэн.<br>3. Дараах ажил гүйцэтгэх гэрээний төслийг бэлтгэн хуулийн хэлтэст хүргүүлэн хянуулсан. Үүнд:<br>- “Гаалийн байгууллагын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 2.1-д заасан зорилтын хүрээнд “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын 2.1.1 буюу Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүргийн хэрэгжилтийг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж, санал боловсруулах ажил гүйцэтгэх гэрээний төсөл,<br>- ГЕГ болон харьяа гаалийн газар, хороодын нийт 21 албан хаагчийг “Эрхэс сувд” ХХК-ийн 124 цагийн “ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалт”-д цахимаар хамруулах ажлыг гүйцэтгэх гэрээний төсөл. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4. Гаалийн байгууллагын "Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг"-т тусгагдсан зорилго, зорилтын 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг нэгтгэж 2025.06.05-нд Сангийн яаманд хүргүүлсэн.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>1. Захиргааны удирдлагын газрын чиг үүрэгт хамаарах тогтоол, шийдвэрийн 1-р улирлын биелэлтийг Хуулийн хэлтэст хугацаанд нь хүргүүлэн ажилласан.<br>2. Гаалийн байгууллагын "Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг"-т тусгагдсан зорилго, зорилтын 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг ЗББНДБ-уудаас авч, нэгтгэн 2025.06.05-нд Сангийн яаманд хүргүүлсэн. | | |
| 11 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 50% | **Биелэлт:**<br>Захиргааны удирдлагын газрын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг таньж тогтоон ангилж, сан үүсгэх зорилгоор 2025 оны 2 дугаар сард нийт 20 асуулт бүхий нэгжийн эрсдэлийг тогтоох цахим судалгааг ЗУГ-ын нийт ГУАБ, ГУБ нараас авч нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ хийсэн. Дүнг үндэслэн нийт 8 эрсдэлийг таньж тогтоон санал боловсруулж, удирдлагад танилцуулан ДХАБХ-т 2025.03.14-ний өдрийн 01100/40 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн. Цахим санал асуулгаар илэрсэн нэгжийн эрсдэлийг ангилж, Excel файлаар ДОТООД САН үүсгэж эрсдэлийг бууруулах арга хэмжээг тухай бүр авч ажилласан.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Захиргааны удирдлагын газрын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг таньж тогтоон ангилж, сан үүсгэх зорилгоор цахим судалгааг нэгжийн албан хаагчдаас авч нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ хийж ажилласан. Санал асуулгаар нийт 8 эрсдэлийг таньж тогтоон санал боловсруулж, удирдлагад танилцуулан ДХАБХ-т дотоод зурвасаар хүргүүлэн ажилласан. Цахим санал асуулгаар илэрсэн нэгжийн эрсдэлийг ангилж, Excel файлаар ДОТООД САН үүсгэж эрсдэлийг бууруулах арга хэмжээг тухай бүр авч ажилласан. | 01.01-06.10 | 100 |
| 12 | Албан хаагчдын ажлын цаг ашиглалт, албан томилолтод хяналт тавьсан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 99% | 50% | **Биелэлт:**<br>1. "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 9.3.1-т "Албан хаагчийн ажилд ирсэн, явсан цагийг бүртгэх, тооцох, хянах системийг байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан тогтоож мөрдөнө" гэж заасны дагуу албан хаагчдын царайг цаг бүртгэлийн төхөөрөмжид таниулан, ажлын цаг ашиглалтад ЗДАС программаар хяналт тавин ажилласан. ЗББНДБ-ын албан хаагчдын 01-05 дугаар сарын эхний болон сүүлийн хагасын цалингийн цагийн тооцоо гарган ААУА-нд хүргүүлсэн. Ажлаас хоцорсон албан хаагчдын бүртгэлээр /явсан , ирсэн/ ажлын цаг ашиглалтын судалгаа гарган ажиллаж байна.<br>2. ГЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу нийт 26 томилолтын хуудас олгож, бүртгэлжүүлсэн.<br>3. Нэгжийн ажлын цаг ашиглалт эхний хагас жилд 100 хувь байна. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Хүрсэн түвшин:**<br>Албан хаагчдын цаг бүртгэлийг царай таних төхөөрөмжид таниулан, ажлын цаг ашиглалтад ЗДАС програмаар хяналт тавин ажиллаж байна. Сар бүрийн 10, 25 албан хаагчдын цалинг ЗДАС программаас шүүж цагийн тооцоо гарган ААУА-нд ДЗ-аар хүргүүлэн ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилд ажлаас хоцорсон, ажил тасалсан албан хаагчдын судалгааг гарган холбогдох нэгжүүдэд сүүлийн хагас жилд зөрчил дутагдлыг арилгах талаарх ДЗ хүргүүлэхээр ажиллаж байна. Тайлант хугацаанд ГЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу нийт 26 томилолтын хуудас олгож, аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч ажилласан. Нэгжийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт тайлант хугацаанд 100 хувь байна. | | |
| 13 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт / Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцасны загварыг эрх бүхий албан тушаалтнаар батлуулаагүй/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 50% | **Биелэлт:**<br>ГЕГ-ын даргын 2021 оны А/251 дүгээр тушаалын хавсралтаар батлуулсан "Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам"-ын хавсралтаар батлуулсан гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийн нэр, төрөлд нийцүүлэн дүрэмт хувцасны ажлын зураглал, техник эдийн засгийн үзүүлэлтийг гүйцэтгүүлэх ажлын үнийн судалгааг хийж, тухайн салбарын аж ахуйн нэгжүүдээс үнийн саналыг авч ажилласан. Ирүүлсэн үнийн судалгаанаас харахад тендер зарлах хэмжээний төсөвт өртөгтэй байгаа тул Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцасны ажлын зураглал, техник эдийн засгийн үзүүлэлтийг боловсруулах ажлын зардлын төсвийг Гаалийн байгууллагын 2026 оны төсвийн төсөлд тусгуулах саналыг 2025.05.28-ны өдрийн 01100/86 дугаартай дотоод зурвасаар СХОГ-т хүргүүлэн ажилласан.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг"-ийн эх загварын зургийг гаргуулах ажлын үнийн судалгааг хийсэн. | 01.01-06.10 | 100 |
| | | | | | **Зорилт 1. Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх** | | |
| 1 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт / Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд стандарт нэвтрүүлэх/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 50% | **Биелэлт:**<br>Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд тус ажлыг хэрэгжүүлэх аж ахуйн нэгжид олгох ажлын даалгавартай танилцсан. Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд ISO 9001:2015 "Чанарын удирдлагын тогтолцоо", ISO 27001:2022 "Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо" стандартыг нэвтрүүлэх ажлын хэсэгт тус нэгжийн гаалийн улсын ахлах байцаагч М.Жавхлантөгс, гаалийн улсын байцаагч Х.Мөнхцэцэг нар ажиллаж байна.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд ISO 9001:2015 "Чанарын удирдлагын тогтолцоо", ISO 27001:2022 "Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо" стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд "Менежмент ба ур чадварын хүрээлэн" төрийн бус байгууллагатай "Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гэрээ"-г байгуулж, хамтран ажиллаж байна. Уг стандартыг нэвтрүүлэх ажлын хэсэгт тус нэгжийн гаалийн улсын ахлах байцаагч М.Жавхлантөгс, гаалийн улсын байцаагч Х.Мөнхцэцэг нар орж ажиллахаар нэр хүргүүлсэн. | | |
| **Зорилт 2. Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах** | | | | | | | |
| 1 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 50% | **Биелэлт:**<br>2025 оны эхний хагас жилийн байдлаар Захиргааны удирдлагын газарт:<br>•Захиргааны зөвлөлийн хуралдаанаар өгөгдсөн 1 үүрэг даалгавар (100) албан бланкаар,<br>•Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй,<br>•Тухайлан газар, нэгжүүдэд оноосон Үүрэг даалгавар 4 буюу биелэлт оруулах хугацаа болоогүй 2 үүрэг даалгавар, 2 үүрэг даалгавар (100),<br>•Цаг үеийн шинжтэй өгөгдсөн 2 үүрэг даалгавар (100),<br>•Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 16 зөвлөмж бүхий үүрэг даалгаврыг өгсөн. Захиргааны удирдлагын газарт өгсөн нийт 6 үүрэг даалгавар, 16 зөвлөмжийг ирүүлсэн бөгөөд нийт дунджаар 96 хувиар буюу 4.8 оноогоор дүгнэгдсэн.<br>ЗДАС-ын Үүрэг даалгаврын программаар хяналт тавих ажлын хүрээнд хугацаандаа биелэлт илгээгүй тохиолдолд 100 хувиар үнэлэх боломжгүй тохиргоог Мэдээллийн технологийн газарт чиглэл өгч тохиргоог нэмэлтээр хийлгэж ажилласан.<br>ГЕГ-ын удирдлага болон ЗББНДБ-уудын дарга нараас өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд программын ХЯНАЛТ төрлөөр нийт үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Хугацаандаа биелэлт оруулаагүй, илгээсэн төлөвтэй, биелэлт дүгнэхгүй байгаа ЗББНДБ болон ХГГХ-ыг нэр цохон дотоод сүлжээ болон тайлан төлөвлөгөө хариуцсан албан хаагчдын группэд байршуулан тухай бүр хяналт тавьж ажиллаж байна.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>1. Тайлант хугацаанд Захиргааны удирдлагын газарт Захиргааны зөвлөлийн хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгавар 1, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 16 зөвлөмж бүхий үүрэг даалгаврыг тус тус ирүүлснийг биелэлтийг бүрэн хангаж ажилласан. Ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг ЗДАС программд оруулж ажилласан. Тус нэгжид ирүүлсэн үүрэг даалгаврыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.2 хувиар буурсан байна.<br>2. ЗДАСП-ын Үүрэг даалгаврын программаар хяналт тавих ажлын хүрээнд хугацаандаа биелэлт илгээгүй тохиолдолд 100 хувиар үнэлэх боломжгүй тохиргоог Мэдээллийн технологийн газарт чиглэл өгч тохиргоог нэмэлтээр хийлгэж ажилласан. ГЕГ-ын удирдлага болон ЗББНДБ-уудын дарга нараас өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд программын ХЯНАЛТ төрлөөр нийт үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Хугацаандаа биелэлт оруулаагүй, илгээсэн төлөвтэй, биелэлт дүгнэхгүй байгаа ЗББНДБ болон ХГГХ- | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ын нэр цохон дотоод сүлжээ болон тайлан төлөвлөгөө хариуцсан албан хаагчдын группэд байршуулан тухай бүр хяналт тавьж ажиллаж байна. | | |
| **Зорилт 4. Соён гэгээрүүлэх** | | | | | | | |
| 1 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Олон нийтийн арга хэмжээ, уулзалт, хурал, ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулна/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 50% | **Биелэлт:**<br>Олон нийтийн арга хэмжээ, уулзалт, хурал, ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах ажлын хүрээнд:<br>1. Гаалийн байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн 2025.02.06-07-ны өдрүүдэд Гаалийн ерөнхий газрын төв байранд зохион байгуулагдсан бөгөөд тус сургалт, зөвлөгөөний бэлтгэл ажлыг хангаж төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж, амжилттай зохион байгуулсан.<br>2. XVII жарны Модон Могой жилийн сар шинийн баярыг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын золголтын арга хэмжээг ААҮА-тай хамтран зохион байгуулсан.<br>3. Гаалийн байгууллагын ахмадын нэгдсэн хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Улаанбаатар хот дахь гаалийн газрын хурлын танхимд амжилттай зохион байгуулсан. Үүнд:<br>-Хурлын хөтөлбөрийг боловсруулж, ЗУГ-ын даргаар батлуулсан.<br>-Хуралд танхимаар болон цахимаар оролцох ахмадуудын тоог авч, нэгтгэн гаргасан.<br>-Хурлын танхим, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах ажлын чиглэлийг Улаанбаатар хот дахь гаалийн газарт өгсөн.<br>-Мөн цахимаар оролцох ахмадуудын оролцоо, сүлжээний бэлэн байдлыг хангах чиглэлийг харьяа гаалийн газар, хороодод өгсөн.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Тайлант хугацаанд Захиргааны удирдлагын газраас гаалийн байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн, XVII жарны Модон Могой жилийн сар шинийн баярыг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын золголтын арга хэмжээ, гаалийн байгууллагын ахмадын нэгдсэн хурлыг тус тус холбогдох ЗББНДБ-уудтай хамтран зохион байгуулан ажилласан. | 01.01-06.10 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино, дунд хугацааны болон цахим сургалтад хамрагдах | Сургалтын тоогоор | 2 сургалтад хамрагдсан. | 1 сургалтад хамрагдсан байна. | Засгийн газрын хэрэг эрхлэх газар, БНСУ-ын КОЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн "Төрийн албаны гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх нь төслийн зөвлөх үйлчилгээний тайланг танилцуулах арга хэмжээнд 2025.04.04-ний өдөр оролцсон. | 01.01-06.10 | 100 |
| 2 | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, заавbegin тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, заавриг тухай бүр нь уншиж судлан хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн. | Хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна. | Шинээр батлагдан гарсан дараах 2 тогтоолыг бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн. Үүнд:<br>-"Журам батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтуудаар батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам".<br>-"Журам шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 243 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох журам", 2 дугаар хавсралтаар батлагдсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам".<br>Шаардлагатай тогтоол, шийдвэрийг ЗДАС программ болон мэдээллийн самбар, дотоод сүлжээгээр нийт албан хаагч нарт танилцуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан. | 01.01-06.10 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ: ........................ /М.ЖАВХЛАНТӨГС/ 2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ М.ЖАВХЛАНТӨГСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Захиргааны удирдлагын газар

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | |
| 1 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, эрх зүйн актын хэрэгжилт | 55 | 10 | 65 | |
| 2 | Гаалийн байгууллагын стратеги төлөвлөгөө болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн | 60 | 5 | 65 | |
| 3 | Хөдөлмөрийн дотоод журам, Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандартын хэрэгжилт, үр дүн | 60 | 5 | 65 | |
| 4 | Албан хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, албан хаагчийн хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах | 55 | 10 | 65 | |
| 5 | Мэргэжлийн зөвлөл, Захиргааны зөвлөлийн хуралдаан болон цахим, шуурхай хурлын шийдвэрийн хэрэгжилт, үр дүнг тооцож тайлагнах | 60 | 5 | 65 | |
| 6 | Архив, албан хэрэг хөтлөлтийн дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах | 56 | 10 | 66 | |
| 7 | Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар хороодын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, удирдамж чиглэлээр хангаж ажилласан байдал | 55 | 10 | 65 | |
| 8 | Авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан ажил | 60 | 5 | 65 | |
| 9 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 55 | 10 | 65 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилтийг хугацаанд тайлагнах | 60 | 5 | 65 | |
| 11 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх | 55 | 10 | 65 | |
| 12 | Албан хаагчдын ажлын цаг ашиглалт, албан томилолтод хяналт тавьсан байдал | 60 | 5 | 65 | |
| 13 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт / Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцасны загварыг эрх бүхий албан тушаалтнаар батлуулаагүй/ | 58 | 6 | 64 | |
| **Зорилт 1. Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх** | | | | | |
| 14 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт / Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд стандарт нэвтрүүлэх/ | 55 | 10 | 65 | |
| **Зорилт 2. Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах** | | | | | |
| 15 | Үүрэг даалгаврын биелэлт | 60 | 5 | 65 | |
| **Зорилт 4. Соён гэгээрүүлэх** | | | | | |
| 16 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Олон нийтийн арга хэмжээ, уулзалт, хурал, ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулна/ | 60 | 5 | 65 | |
| **Дундаж оноо:** | | | | 65.0 | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино, дунд хугацааны болон цахим сургалтад хамрагдах | 100% | 15 | |
| 2 | Төрийн байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах заалтын дагуу Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлнэ. | 100% | 15 | |
| **Дундаж оноо:** | | | 15 | |

### 3. **Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4 | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| | **Дундаж оноо:** | 7 | |

### 4. **Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1 | Хандлага, ёс зүй | 8 |
| 2 | Багаар ажиллах | 8 |
| 3 | Харилцаа | 8 |
| | **Дундаж оноо:** | 8 |

### 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | 65 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | 7 |
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 8 |
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | - |
| **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 95.0 |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга:***
Захиргааны удирдлагын газрын даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .............................. (Б.Хосбаяр)

........................*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын ахлах байцаагч .............................. (М.Жавхлантөгс)

........................*(огноо)*

***Үнэлгээг хянасан :***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч .............................. (Г.Энхтайван)

.......................... *(огноо)*

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын
ахлах байцаагч .............................. (Ө.Тэгшээ)

2025.06.25 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч:***
Гаалийн ерөнхий газрын дарга .............................. (Р.Отгонжаргал)

2025.06.25 *(огноо)*